



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бигэр сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/06/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр	
	Утас: 70483413	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг	
	Утас: 70484055	Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
	Ахлах аудитор: Ж.Бүжинханд	
	Утас: 99177546	Цахим хаяг: Bujiinkhandj@audit.gov.mn
	Аудитор	Г.Энхдэлгэр
	Утас: 70484030	Цахим хаяг: Enkhdelgerg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 61

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Бигэр сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Бигэр сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

07920336

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	142,694,665.00	159,570,140.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
31210	Төгрөг	0.00	0.00
31211	Төрийн сангийн харилцах	0.00	0.00
33	АВЛАГА	47,454,445.00	30,154,445.00
33500	Бусад авлага	47,454,445.00	30,154,445.00
33510	Байгууллагаас авах авлага	47,454,445.00	30,154,445.00
35	БАРАА МАТЕРИАЛ	95,240,220.00	97,115,695.00
35400	Хангамжийн материал	95,240,220.00	97,115,695.00
35410	Бичиг хэргийн материал	1,170,950.00	925,000.00
35420	Аж ахуйн материал	1,133,665.00	2,257,085.00
35440	Түлш, шатах тослох материал	6,045,605.00	4,978,160.00
35450	Барилгын засварын материал	8,630,000.00	9,485,450.00
35600	Мал амьтад	69,340,000.00	69,100,000.00
35470	Бусад хангамжийн материал	8,920,000.00	10,370,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	-	32,300,000.00
36900	БЗЭ буй эргэлтийн бус хөрөнгө	-	32,300,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	830,834,244.69	1,411,938,683.52
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	830,834,244.69	1,411,938,683.52
39200	Биет хөрөнгө	827,169,970.87	1,408,730,875.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	814,254,487.17	1,115,685,877.07
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(271,797,713.76)	(281,534,858.69)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	146,529,025.00	148,867,960.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(90,309,415.21)	(97,761,460.69)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	108,056,320.00	92,699,079.00
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(47,637,594.85)	(47,765,985.04)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,825,244.85	20,950,574.73
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(16,876,844.49)	(9,525,160.87)
39214	Бусад үндсэн хөрөнгө	165,563,122.00	499,900,762.00
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	(14,436,659.84)	(32,785,912.09)
39300	Биет бус хөрөнгө	3,664,273.82	3,207,808.10
39301	Програм хангамж	3,850,000.00	3,850,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(3,061,726.18)	(3,518,191.90)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,876,000.00	2,876,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	973,528,909.69	1,571,508,823.52
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	973,528,909.69	1,571,508,823.52
51	Засгийн газрын хувь оролцоо	973,528,909.69	1,571,508,823.52
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	257,131,132.14	257,131,132.14
51200	Хуримтлагдсан үр дүн	420,758,968.20	1,018,738,882.03
51210	Өмнөх үеийн үр дүн	420,758,968.20	420,758,968.20
51220	Тайлант үеийн үр дүн	-	597,979,913.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	295,638,809.35	295,638,809.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	973,528,909.69	1,571,508,823.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	425,798,971.35	1,076,098,647.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	46,948,397.35	735,651,824.80
1200	Нийтлэг татварын бус орлого	46,948,397.35	735,651,824.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	46,948,397.35	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	46,948,397.35	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	671,537,387.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	64,114,437.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖ ИЛТИЙН ОРЛОГО	378,850,574.00	340,446,823.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	56,989,274.00	25,683,323.00
131103	ЗГНХ,ЗДНХөрсөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс	-	25,533,323.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод	56,939,274.00	150,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	50,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	321,861,300.00	314,763,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	321,861,300.00	314,763,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	404,091,746.07	448,075,055.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	404,091,746.07	448,075,055.02
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	389,365,566.48	440,227,211.05
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	227,556,246.13	229,814,241.00
210101	Үндсэн цалин	169,430,685.13	172,119,290.00
210102	Нэмэгдэл	37,957,561.00	38,004,432.00
210105	Гэрээт ажлын цалин	20,168,000.00	19,690,519.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,233,389.51	29,272,549.00
210201	Тэтгэврийн даатгал	19,604,489.51	20,061,949.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,725,800.00	2,302,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	431,400.00	1,842,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,157,200.00	460,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,314,500.00	4,605,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,246,556.77	15,086,220.03
210301	Гараг, цахилгаан	2,395,327.77	1,878,820.03
210302	Түлш, халаалт	11,772,000.00	13,127,400.00
210303	Цэвэр, бохир ус	79,229.00	80,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,371,362.00	15,010,262.80
210401	Бичиг хэрэг	1,637,150.00	1,791,430.00
210402	Тээвэр, шатахуун	9,446,847.00	9,511,312.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,766,450.00	1,273,800.00
210404	Ном, хэвлэл	11,980.00	85,620.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150,000.00	190,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	979,900.00	1,982,400.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	379,035.00	175,100.00
2105	Нормативт зардал	1,093,500.00	1,084,000.00
210502	Хоол, хүнс	493,500.00	484,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,320,900.00
210604	Урсгал засвар	-	1,320,900.00
2107	Томилголт, зочны зардал	2,855,400.00	4,077,000.00
210702	Дотоод албан томилголт	2,855,400.00	4,077,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,330,912.00	352,896.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	2,900,874.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	163,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	299,038.00	160,688.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,000.00	-
210807	Газрын төлбөр	24,000.00	28,858.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	97,678,200.07	144,209,142.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,172,875.00	52,317,373.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	2,296,000.00	450,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	63,645,760.07	91,441,769.22
210904	Нөйдөөргүй авлалын алдагдал	16,563,565.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,726,179.59	7,847,843.97
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	5,300,879.59	6,377,843.97
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,300,879.59	6,377,843.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,425,300.00	1,470,000.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжл	7,236,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,189,000.00	1,470,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,681,000.00	30,043,678.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-II)	21,707,225.28	628,023,592.78
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	15,681,000.00	30,043,678.95
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	15,681,000.00	30,043,678.95
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	191,178.95
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	15,681,000.00	29,852,500.00
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	6,026,225.28	597,979,913.83

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	НИЙТ ДҮН
1	ҮЛДЭГДЭЛ	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
8	ҮЛДЭГДЭЛ	257,131,132.14	295,638,809.35	420,758,968.20	973,528,909.69
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	257,131,132.14	295,638,809.35	420,758,968.20	973,528,909.69
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
13	Орлогын тайланд хүлээн зөв шөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
15	Тайлант үеийн үр дүн	-	-	597,979,913.83	597,979,913.83
16	ҮЛДЭГДЭЛ	257,131,132.14	295,638,809.35	1,018,738,882.03	1,571,508,823.52

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖ ИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	386,519,894.00	387,901,268.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	386,519,894.00	387,901,268.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	64,658,594.00	73,137,768.00
131103	ЗГНХ,ЗДНХөрсөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц	7,669,320.00	25,533,323.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	56,939,274.00	47,604,445.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	50,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	321,861,300.00	314,763,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	321,861,300.00	314,763,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	374,901,894.00	385,701,268.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	374,901,894.00	385,701,268.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	312,721,269.41	347,698,979.03
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	227,084,761.00	230,115,290.00
210101	Үндсэн цалин	167,959,200.00	171,819,290.00
210102	Нэмэгдэл	37,957,561.00	38,128,000.00
210105	Гэрээт ажлын цалин	21,168,000.00	20,168,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,704,874.64	28,971,500.00
210201	Тэтгэврийн даатгал	20,075,974.64	19,760,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,725,800.00	2,302,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	431,400.00	1,842,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,157,200.00	460,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,314,500.00	4,605,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,997,056.77	13,480,320.03
210301	Гэрэл, цахилгаан	2,395,327.77	1,567,617.03
210302	Түлш, халаалт	13,522,500.00	11,832,703.00
210303	Цэвэр, бохир ус	79,229.00	80,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,940,890.00	15,710,100.00
210401	Бичиг хэрэг	2,494,600.00	1,495,480.00
210402	Тээвэр, шатахуун	10,280,960.00	10,024,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,766,450.00	1,273,800.00
210404	Ном, хэвлэл	11,980.00	85,620.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	190,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,186,900.00	2,640,400.00
2105	Нормативт зардал	1,093,500.00	1,084,000.00
210502	Хоол, хүнс	493,500.00	484,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	894,150.00
210604	Урсгал засвар	-	894,150.00
2107	Томилот, зочны зардал	2,855,400.00	4,077,000.00
210702	Дотоод албан томилот	2,855,400.00	4,077,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,330,912.00	352,896.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	2,900,874.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	163,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	299,038.00	160,688.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,000.00	-
210807	Газрын төлбөр	24,000.00	28,858.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,713,875.00	53,013,723.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,172,875.00	52,513,723.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	2,541,000.00	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,180,624.59	38,002,288.97
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	52,755,324.59	36,532,288.97
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,300,879.59	6,377,843.97
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	47,454,445.00	30,154,445.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,425,300.00	1,470,000.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,236,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,189,000.00	1,470,000.00
3	ҮЙЛ АЖ ИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III-II)	11,618,000.00	2,200,000.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	11,618,000.00	2,200,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,618,000.00	2,200,000.00
223	БУСАД ХӨРӨНГӨ	11,618,000.00	2,200,000.00
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,618,000.00	2,200,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI-IV-V)	(11,618,000.00)	(2,200,000.00)
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖ ИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	-
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖ ИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖ ИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (V-III+VI+VII)	-	-
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	Цэвэр гүйцэтгэл
		Батлагдсан төлөвлөгөө	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	314,763,500.0	308,385,656.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	314,763,500.0	308,385,656.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	313,263,500.0	306,915,656.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	230,266,400.0	230,115,290.00
210101	Үндсэн цалин	171,920,400.0	171,819,290.00
210102	Нэмэгдэл	38,178,000.0	38,128,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,168,000.0	20,168,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,971,500.0	28,971,500.00
210201	Тэтгэврийн даатгал	19,760,900.0	19,760,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,302,700.0	2,302,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,842,100.0	1,842,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	460,500.0	460,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,605,300.0	4,605,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,250,000.0	13,480,320.03
210301	Гэрэл, цахилгаан	2,250,000.0	1,878,820.03
210302	Түлш, халаалт	11,920,000.0	11,521,500.00
210303	Цэвэр, бохир ус	80,000.0	80,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,428,600.0	15,710,100.00
210401	Бичиг хэрэг	1,500,000.0	1,495,480.00
210402	Тээвэр, шатахуун	10,028,600.0	10,024,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,850,000.0	1,273,800.00
210404	Нөм, хэвлэл	150,000.0	85,620.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ар	200,000.0	190,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,700,000.0	2,640,400.00
2105	Нормативт зардал	1,100,000.0	1,084,000.00
210502	Хоол, хүнс	500,000.0	484,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.0	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,900,000.0	1,894,150.00
210604	Урсгал засвар	1,900,000.0	1,894,150.00
2107	Томилолт, зочны зардал	4,900,000.0	4,077,000.00
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	4,900,000.0	4,077,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	1,547,000.0	352,896.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	680,000.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	350,000.0	163,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.0	160,688.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	187,000.0	-
210807	Газрын төлбөр	30,000.0	28,858.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,900,000.0	11,230,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,400,000.0	10,730,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.0	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,000.00	1,470,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.0	1,470,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.0	1,470,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖ ҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	314,763,500.0	308,385,656.03
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	314,763,500.0	308,385,656.03
132001	Орон нутгийн төсвөөс	314,763,500.0	308,385,656.03
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	73,137,768.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	73,137,768.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	42,983,323.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	42,983,323.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		42,983,323.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	30,154,445.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	30,154,445.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг		30,154,445.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	73,137,768.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	73,137,768.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	25,533,323.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	47,604,445.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бигэр сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхдэлгэр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Бигэр сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бигэр сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нь цаг үеэ олсон, оновчтой зөвлөгөө, мэдээллээр ханган бүх талын дэмжлэг үзүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд

хүртээмжтэй чанарын өндөр түвшинд хүргэх чиг үүрэгтэй сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бигэр сумын Засаг даргын тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 320.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 6.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 5.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн зардлын 448.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 8.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 7.1 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бигэр сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 61 хувиар буюу 598.0 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 97.1 сая төгрөг болж 1.9 сая төгрөгөөр өссөн нь 31.8 сая төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авсан. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 30.7 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 31.5 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 97.1 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,884.8 сая төгрөг болж 609.9 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 2.2 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 670.5 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой байна. Тайлант онд 62.9 сая төгрөгийн хөрөнгийг акталсан ба тайлант оны эцэст 1,884.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Авлага дансны үлдэгдэлд нэмэлт санхүүжилтийн данснаас татан төвлөрүүлсэн 30.2 сая төгрөгийн авлага байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,884.8 сая төгрөг болж 598.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 1,018.7 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 383.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 314.8 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 314.8 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 308.4 сая төгрөгийг зарцуулж 6.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 308.4 сая төгрөг буюу 98.0 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 0.2 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 0.8 сая төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 0.7 сая төгрөгөөр, томиллолт, зочны зардлыг 0.8 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,

хураамжийг 1.2 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 2.7 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 73.1 сая төгрөгийн санхүүжилт орж, урсгал зардалд 10.6 сая төгрөг, хөрөнгийн зардалд 32.3 сая төгрөг зарцуулж, 30.2 сая төгрөгийг татан төвлөрүүлж авлагаар тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт үзлээ.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 153 мэдээллээс 151 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна.

3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд 40.6 төгрөгийн гүйлгээнд төлбөрийн баримт аваагүй байна. Аудитын хугацаанд 26.3 сая төгрөгийн төлбөрийн баримт цахим системд нөхөн шивүүлж, 14.3 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг дутуу шивүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, Татварын ерөнхий хуулийн 28., 2-т "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 45.6 сая төгрөгийн төлбөрийн акт, 17.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар төсвийн хэмнэлтийн горимыг баримталж ажиллаж буй эсэхийг, мөн тээвэр шатахууны зарцуулалт, норм, бараа материалын тулгалтыг үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 74.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 58.6 сая төгрөгийн алдааг залруулж, 15.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад тайлант хугацаанд шивүүлээгүй 26.3 сая төгрөгийн төлбөрийн баримтыг нөхөж шивүүлсэн, санхүүгийн байдлын тайланд 32.3 сая төгрөгийн залруулга хийсэн.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Албан шаардлага

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 1.2 сая төгрөгөөр тоног төхөөрөмж бэлтгэсэн нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 3.1.2-т "урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоод албан томилолтын зардал, энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 0.4 сая төгрөгийн зөрүү тооцоо татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тайлант хугацаанд 14.3 сая төгрөгийн гүйлгээнд төлбөрийн баримт аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг

бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэж заасныг зөрчсөн бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 55.5 сая төгрөгийн мөнгөн гүйлгээг мэдээлээгүй.

1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.

2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говь-Алтай аймгийн Бигэр сумын Засаг даргын тамгын газар	7	74.5	2	58.6			4	15.9	1	0

/сая төгрөгөөр/